



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 06

Мандалговь

“Хүний нөөцийг дэмжих” дэд хөтөлбөр  
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын “Шинэ сэргэлтийн бодлого” батлах тухай 2021 оны 106 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Хүний нөөцийг дэмжих” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, арга хэмжээний төлөвлөгөөг батлан, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийг улс, орон нутгийн төсөв, аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд жил бүр тусган, хэрэгжилт үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ш.Энхсүх)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү дэд хөтөлбөр баталсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ж.МӨНХЧУЛУУН



۱۱۔ فہرست پروفیسرز کے ناموں پر مشتمل فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

(6) و ایچ 2022ء کے ناموں پر مشتمل فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۱۲۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

(7) و ایچ 2022ء کے ناموں پر مشتمل فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۱۳۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۱۴۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۱۵۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۱۶۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۱۷۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۱۸۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۱۹۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۲۰۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔

۲۱۔ فہرستیں مندرجہ ذیل کے ناموں پر تیار کی جائیں گی۔



حکومت پنجاب  
پنجاب حکومت  
پنجاب حکومت

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн  
06 дугаар тогтоолын хавсралт



“ХҮНИЙ НӨӨЦИЙГ ДЭМЖИХ” ДЭД ХӨТӨЛБӨР

(2025-2028 он)

## АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ЗУРГАА. ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР, САНХҮҮЖИЛТ

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

## **Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөр боловсруулах үндэслэл болно.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго**

Төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлж, эцсийн үр дүнг дээдэлсэн, урамшуулал хариуцлагын тогтолцоо бүхий чадахуйн зарчимд тулгуурласан мэргэшсэн, чадварлаг төрийн албыг бүрдүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн өрсөлдөх чадвар, удирдлагын манлайллыг дээшлүүлэхэд оршино.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

**Зорилт 1.** Аймаг орон нутагт шаардлагатай боловсон хүчнийг салбар бүрд тасралтгүй бэлтгэж, боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ.

#### **Үйл ажиллагаа**

- 3.1.1 Орон нутагт хэрэгцээтэй, нэн шаардлагатай боловсон хүчнийг шинээр бэлтгэх
- 3.1.2 Аймгийн хэмжээнд шаардлагатай байгаа мэргэжилтэй боловсон хүчний хэрэгцээний судалгааг жил бүр салбар, салбараар гаргах
- 3.1.3 ЕБС төгсөгчдөд ажил, мэргэжлийн онцлогоо танилцуулж, тэднийг орон нутагт шаардлагатай байгаа мэргэжил сонгон авч суралцуулах чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг, үзүүлэх сургалт зэрэг үйл ажиллагааг байгууллага бүр зохион байгуулах
- 3.1.4 Их дээд сургуулиудтай хамтран ажиллах гэрээ байгуулан дутагдалтай хүний нөөцийг бэлтгэх
- 3.1.5 Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутан залуучуудтай гэрээ байгуулан сургалтын төлбөрийн дэмжлэгт хамруулах

**Зорилт 2.** Төрийн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх замаар тогтвортой байдлыг хангана.

## Үйл ажиллагаа

- 3.2.1 Шаардлагатай төрийн албан хаагчдад орон байр болон эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх
- 3.2.2 Төрийн албанд шинээр орж байгаа албан хаагчийг сургаж, бэлтгэх, мэргэшүүлэх
- 3.2.3 Шинээр томилогдсон төрийн албан хаагчдыг Удирдлагын академийн төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх
- 3.2.4 Шинээр томилогдсон албан хаагчдыг “Сургаж - дадлагажуулахад” дэмжлэг үзүүлэх
- 3.2.5 Төрийн захиргааны албан хаагчид тавигдах ерөнхий болон тусгай шаардлага хангасан хүний нөөцийн санг сум, байгууллага бүр бий болгон боловсон хүчнээ бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.2.6 Төрийн албан хаагчдын ёс зүй, удирдлагын манлайллыг сайжруулах сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, мэдлэгээ тэлэх боломж бүрдүүлэх
- 3.2.7 Орон нутагт сайн туршлагыг нэвтрүүлэх санал, санаачилгыг дэмжих зорилгоор гадаад, дотоодод туршлага судлах ажлыг зохион байгуулах
- 3.2.8 Мэдлэг боловсрол, ур чадвар, мэргэжлээ дээшлүүлэхээр суралцаж байгаа төрийн албан хаагчдыг сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх
- 3.2.9 Төрийн байгууллагыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
- 3.2.10 Төрийн албан хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
- 3.2.11 ISO9001 Чанарын удирдлагын тогтолцоо стандартыг төрийн байгууллагуудад хэрэгжүүлэх, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.2.12 Орон нутагт ирж ажиллаж байгаа төрийн албан хаагчдад орон байрны дэмжлэг үзүүлэх
- 3.2.13 Төрийн албан хаагчдыг байр орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах, орон сууц барих газрын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.2.14 Шаардлагатай сумдын хүний нөөцийн сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- 3.2.15 Орон нутагт шилжин ажиллаж байгаа төрийн албан хаагчийн байр орон сууцны түрээсийн төлбөрийг 3 хүртэлх жилийн хугацаанд дэмжлэг үзүүлэх
- 3.2.16 Эрүүл мэндийн тусламж, дэмжлэг нэн шаардлагатай төрийн албан хаагчдад эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх
- 3.2.17 Орон нутагт шилжин ирж ажиллаж байгаа албан хаагчийн гэр бүлийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх
- 3.2.18 Салбар салбартаа амжилт гаргасан төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг багаар нь дэмжих
- 3.2.19 Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд үндэслэн урамшуулах
- 3.2.20 ISO9001 Чанарын удирдлагын тогтолцоог өөрийн болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр нэвтрүүлсэн сум, байгууллагыг урамшуулах
- 3.2.21 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад тогтвор суурьшилтай ажиллаж байгаа их эмч нарт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмж олгох

**Зорилт 3.** Аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах санал санаачилгыг дэмжих замаар бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

#### **Үйл ажиллагаа**

- 3.3.1 Аж ахуйн нэгж, байгууллагын дутагдалтай боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.3.2 Аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх
- 3.3.3 Аж ахуйн нэгж байгууллагад нэн шаардлагатай боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.3.4 Аж ахуйн нэгж, байгууллагын орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжүүлэх, боловсон хүчнээ мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх
- 3.3.5 Орон нутагт сайн туршлагыг нэвтрүүлэх санал, санаачилгыг дэмжиж гадаад, дотоодод туршлага судлахад хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх

#### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

- 4.1. Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

### **Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

- 5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах
- 5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож байгаа төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

### **Зургаа. Хөтөлбөрийн эх үүсвэр, санхүүжилт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- 6.1. Төрийн байгууллагын төсөв, өөрийн орлого
- 6.2. Улсын болон орон нутгийн төсөв
- 6.3. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж, дэмжлэг
- 6.4. Олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилт

### **Долоо. Хөтөлбөрийн хүрэх үр дүн**

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

- 7.1. Боловсон хүчний хангалт 95 хувьд хүрсэн байна.
- 7.2. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн төлөвлөлт, боловсон хүчний нөөц бүрдүүлэлт, сургаж дадлагажуулах ажлын зохион байгуулалт оновчтой болж, төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдал хангагдсан байна.
- 7.3. Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгаа сайжирч, мэргэжлийн боловсон хүчний хангалт нэмэгдэнэ.
- 7.4. Төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадвар дээшилж, ажлын гүйцэтгэл, бүтээмж сайжирна.
- 7.5. Удирдах албан тушаалтнуудын манлайлах ур чадвар дээшилж, төрийн албан хаагчдын бүтээмж нэмэгдэнэ.
- 7.6. Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлага, харилцааны ур чадвар дээшилж, төрийн үйлчилгээний соёл сайжирна.